



# ТА ӨРИЙН УРХИНД ОРООГҮЙ БИЗ...

Өрийн урхи гэж: Өндөр төлбөр бүхий үндсэн зээл, хүүгийн төлбөрөө төлж барагдуулж чадахгүй нөхцөл байдалд орохыг хэлдэг. Олон дахин зээл авах нь өрийн урхинд орох магадлалыг нэмэгдүүлдэг ба төдийлөн анзаарагддаггүй.

Өрийн урхинд орсноор ТА дараах эрсдэлүүдтэй тулгарна.

- Зээлээ төлж чадахгүй болох
- Дахин зээл авах бололцоогүй болох
- Ирээдүйн орлого болгон тань зээлийн төлөлтөд зарцуулагдах
- Сэтгэл санааны дарамт үүсэх

Та 4 болон түүнээс дээш асуултад "Тийм" гэж хариулсан бол хувийн болон өрхийн санхүүдээ анхаарах цаг тань болсон байна.

1

ТА БАЙНГЫН  
ХЭРЭГЦЭЭНДЭЭ  
ЗОРИУЛЖ ЗЭЭЛ  
АВДАГ УУ?

2

ХЭРЭГЛЭЭНИЙ  
ТӨЛБӨРӨӨ ХУГАЦАА  
ХЭТРҮҮЛЭН ТӨЛДӨГ  
ҮҮ?

3

ТА КРЕДИТ КАРТААР  
БАЙНГЫН  
ХЭРЭГЦЭЭГЭЭ  
ХАНГАДАГ УУ?

4

КРЕДИТ КАРТЫН  
ТӨЛБӨРӨӨ ХУГАЦАА  
ХЭТРҮҮЛЖ ТӨЛДӨГ  
ҮҮ?

5

ТА ЗЭЭЛЭЭ  
ТӨЛӨХИЙН ТУЛД  
ДАХИН ЗЭЭЛ  
АВДАГ УУ?

6

ИРЭЭДҮЙН ОРЛОГОО  
БАРЬЦААЛАН ЗЭЭЛ  
АВДАГ УУ?

7

САР БҮРИЙН  
ТОГТМОЛ ТӨЛДӨГ  
ЗАРДЛУУД ТАНЬ  
НЭМЭГДЭЖ БАЙНА  
УУ?

8

ӨӨРТ БАЙГАА  
ТЕХНИКИЙН ХЭРЭГСЛЭЭ  
САЙЖРУУЛАХ  
ЗОРИЛГООР ЗЭЭЛ  
АВДАГ УУ?

9

БАНК НЬ ТАНЫ  
ЗЭЭЛИЙН  
ХҮСЭЛТЭЭС  
ТАТГАЛЗАЖ БАЙСАН  
УУ?

10

ТАНЫ ОРЛОГЫН ЭХ  
ҮҮСВЭРИЙН 50  
ХУВИАС ИЛҮҮ НЬ  
САР БҮРИЙН  
ТОГТМОЛ ЗАРДАЛД  
ЗАРЦУУЛАГДАГ  
УУ?